

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН АГУУЛГА**

I ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл

- 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
- 2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хууль тогтоомж
- 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
- 4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. Төрийн албаны эрхэм зорилго, зарчим,
үйлчилгээний стандарт, санхүүжилт**

- 5 дугаар зүйл. Төрийн албаны эрхэм зорилго
- 6 дугаар зүйл. Төрийн албаны зарчим
- 7 дугаар зүйл. Үйлчилгээний стандарт
- 8 дугаар зүйл. Төрийн албаны санхүүжилт

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. Төрийн албаны ангилал болон төрийн албан
тушаалын төрөл, төрийн албан хаагч, түүний хувийн хэрэг, тоо бүртгэл**

- 9 дүгээр зүйл. Төрийн албаны ангилал болон төрийн албан тушаалын төрөл
- 10 дугаар зүйл. Төрийн албан хаагч
- 11 дүгээр зүйл. Төрийн улс төрийн албан хаагч
- 12 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагч
- 13 дугаар зүйл. Төрийн тусгай албан хаагч
- 14 дүгээр зүйл. Төрийн үйлчилгээний албан хаагч
- 15 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг
- 16 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн тоо бүртгэл

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа
болон төрийн бусад албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн захиргааны
албан хаагчийн зэрэг дэв**

- 17 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа
- 18 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл
- 19 дүгээр зүйл. Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл
- 20 дугаар зүйл. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл
- 21 дүгээр зүйл. Төрийн албан тушаалын зэрэг дэв

II ХЭСЭГ

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ТАВИХ ШААРДЛАГА БОЛОН
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ЖУРАМ,
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ШАЛГАЛТ**

ТАВДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчид тавих шаардлага

22 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавих нийтлэг шаардлага

23 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавих тусгай шаардлага

24 дүгээр зүйл. Мэргэжлийн багц сургалт

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Төрийн албан тушаалд томилох журам

25 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох нийтлэг журам

26 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох үндсэн шалгуур

27 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаалд сонгон шалгаруулж томилох журам

28 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох хугацаа

29 дүгээр зүйл. Албан тушаалын ажлын байрны сургалт

30 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналт

31 дүгээр зүйл. Хориглох зүйл

32 дугаар зүйл. Хариуцлага

ДОЛООДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчийн шалгалт

33 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн шалгалт

34 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн шалгалтын хэлбэр, агуулга

35 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах

36 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн тусгай шалгалтыг зохион байгуулах

37 дугаар зүйл. Хориглох зүйл

38 дугаар зүйл. Хариуцлага

III ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ, НИЙТЛЭГ ҮҮРЭГ, ЭРХ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ, ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

НАЙМДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчийн тангараг

39 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн тангараг

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйл

40 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг

41 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг эрх

42 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

43 дугаар зүйл. Хариуцлага

АРАВДУГААР БҮЛЭГ. Ёс зүйн хэм хэмжээ

44 дүгээр зүйл. Ёс зүйн хэм хэмжээ

45 дугаар зүйл. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

IV ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл

- 46 дугаар зүйл. Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа
- 47 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл
- 48 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам
- 49 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах
- 50 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас нь бууруулах
- 51 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх, чөлөөлөх
- 52 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаалаас нь халах
- 53 дугаар зүйл. Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах
- 54 дүгээр зүйл. Хориглох зүйл
- 55 дугаар зүйл. Хариуцлага

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. Шагнал, мөнгөн урамшуулал

- 56 дугаар зүйл. Шагнал, мөнгөн урамшуулал

V ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл

- 57 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх нийтлэг үндэслэл
- 58 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд баримтлах зарчим

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Стратеги төлөвлөгөө

- 59 дүгээр зүйл. Стратеги төлөвлөгөө
- 60 дугаар зүйл. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах
- 61 дүгээр зүйл. Стратеги төлөвлөгөөний төслийн талаар санал авах

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ. Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө

- 62 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө
- 63 дугаар зүйл. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө
- 64 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

- 65 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайлан

66 дугаар зүйл. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан
67 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ. Аудит

68 дугаар зүйл. Аудит хийх
69 дүгээр зүйл. Аудитын ангилал, зорилго
70 дугаар зүйл. Аудитын дүгнэлт

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ. Олон нийтийн хяналт

71 дүгээр зүйл. Олон нийтийн хяналт
72 дугаар зүйл. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх
73 дугаар зүйл. Олон нийтийн хяналтыг санхүүжүүлэх
74 дүгээр зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөл
75 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн
76 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм
77 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн тайлан

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

78 дугаар зүйл. Засгийн газрын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх
79 дүгээр зүйл. Байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх
80 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

ХОРЬДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, түүний ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

81 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх үндэслэл

82 дугаар зүйл. Төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

83 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Хариуцлага

84 дүгээр зүйл. Төсвийн шууд захирагчид хүлээлгэх хариуцлага
85 дугаар зүйл. Төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлага

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ. Ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах арга хэмжээ

86 дугаар зүйл. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах төлөвлөгөө
87 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах арга хэмжээ

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ. Гүйцэтгэлийн нэгдсэн сан

88 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн сан

VI ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС, НӨХӨХ ТӨЛБӨР, ТУСЛАМЖ БОЛОН НИЙГМИЙН БАТАЛГАА

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Төрийн албан хаагчид олгох цалин хөлс

89 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн цалин хөлс

90 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох журам

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

91 дүгээр зүйл. Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчид олгох тусламж

92 дугаар зүйл. Төрийн албан хаагчид олгох тусламж

ХОРИН ДОЛООДУГААР БҮЛЭГ. Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа

93 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ. Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл баталгаа

94 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл баталгаа

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. Дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч

95 дугаар зүйл. Дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч

VII ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

ГУЧДУГААР БҮЛЭГ. Засгийн газрын чиг үүрэг

96 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

97 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

98 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

99 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн хуралдаан

100 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн

101 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, түүний бүрэн эрх

102 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх

103 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг огцруулах

104 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг нөхөн томилох

105 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүний хууль зүйн баталгаа

106 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ. Маргаан хянан шийдвэрлэх

107 дугаар зүйл. Төрийн албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх

108 дугаар зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ. Бусад зүйл

109 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

----oO----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

I ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь чадахуйн зарчим /мерит/-д суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албаны эрх зүйн үндсийг тогтоож, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хариуцлагыг бэхжүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулах, төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хууль тогтоомж

2.1.Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

3.1.1."төрийн алба" гэж эх орондоо эрүүл, аюулгүй орчинд сэтгэл хангалуун, сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сахиулах болон төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд

хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг;

3.1.2."төрийн албан хаагч" гэж Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн албанд сонгогдсон буюу томилогдсон Монгол Улсын иргэнийг;

3.1.3."Төрийн байгууллага" гэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх шатны байгууллага, түүнчлэн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагыг;

3.1.4."чадахуйн зарчим /мерит/" гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг;

3.1.5."төрийн үйлчилгээ" гэж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сахиулах болон нийтийн эрх ашгийн төлөө төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг;

3.1.6."хөтөлбөр" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.16-д заасан, гүйцэтгэл, үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;

3.1.7."арга хэмжээ" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д заасан, хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо, хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

3.1.8."холбогдох Байнгын хороо" гэж тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлж байгаа гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайланд тусгасан хөтөлбөр, арга хэмжээ эрхлэх асуудлынх нь хүрээнд хамаарч байгаа Улсын Их Хурлын Байнгын хороог;

3.1.9."сул орон тоо" гэж төрийн албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, дэвшүүлсэн, шилжүүлсэн, эсхүл төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, төрийн албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаал суларсан байхыг;

3.1.10."албан тушаалын ажлын байрны тодорхойлолт" гэж тухайн байгууллагын стратеги төлөвлөгөө, бүтцийн нэгжийн чиг үүргийн дагуу тухайн албан тушаалын хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг болон уг ажил, үйлчилгээг гүйцэтгэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хуулиар төрийн албаны эрхэм зорилго, зарчим, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ангилал, зэрэг, нийтлэг эрх, үүрэг, хориглох зүйл, төрийн захиргааны албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын үр дүнг үнэлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах

журам, Төрийн албаны зөвлөлийн эрх зүйн байдал болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулна.

4.2.Төрийн улс төрийн албан хаагчид тавих шаардлага болон түүнийг томилох, чөлөөлөх, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалт, хөгжлийн бодлогыг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хууль үйлчлэхгүй.

4.3.Төрийн тусгай албан хаагчийг томилох, чөлөөлөх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сахилгын шийтгэл ногдуулах, сургалт, хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэмэгдэл баталгаа, ажлын гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4.4.Энэ хууль доор дурдсан төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд үйлчлэхгүй:

4.4.1.шүүх;

4.4.2.прокурорын байгууллага;

4.4.3.зэвсэгт хүчин, хилийн цэрэг;

4.4.4.цагдаагийн алба;

4.4.5.авлигатай тэмцэх газар;

4.4.6.тагнуулын байгууллага;

4.4.7.дипломат алба;

4.4.8.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

4.4.9.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд.

4.5.Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг болон улсын төсвөөс санхүүжүүлдэг, төрийн хэрэгцээ, эрх ашигт зориулсан үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, томилох, чөлөөлөх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалт, хөгжлийн бодлогыг тодорхойлох, нэмэгдэл баталгаа, хөдөлмөрийн харилцаа, ажлын гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хуулиар зохицуулна.

4.6.Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Төрийн албаны эрхэм зорилго, зарчим,
үйлчилгээний стандарт, санхүүжилт**

5 дугаар зүйл. Төрийн албаны эрхэм зорилго

5.1.Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол хүн эх орондоо эрүүл, аюулгүй орчинд сэтгэл хангалуун, сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллаж, эх орон, ард түмэндээ үнэнчээр үйлчлэхэд оршино.

6 дугаар зүйл. Төрийн албаны зарчим

6.1.Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зарчмыг баримтална:

6.1.1.хүний эрхийг хангах;

6.1.2.мэргэшсэн, тогтвортой байх;

6.1.3.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;

6.1.4.Монгол Улсын иргэн төрийн алба хаших адил тэгш боломжтой байх;

6.1.5.төрийн албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчим /мерит/-ыг баримтлах;

6.1.6.төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлах;

6.1.7.ил тод, иргэдийн оролцоо, хяналттай байх;

6.1.8.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

6.1.9.захирах, захирагдах ёс;

6.1.10.цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн байх;

6.1.11.төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг төр хангах.

7 дугаар зүйл. Үйлчилгээний стандарт

7.1.Төрийн албан хаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, иргэдэд ялгаваргүйгээр, шуурхай үйлчлэх хэм хэмжээг тогтоож, үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд төрийн албаны үйлчилгээний стандарт /цаашид “үйлчилгээний стандарт” гэх/ чиглэнэ.

7.2.Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагаас бусад байгууллагын үйлчилгээний стандартыг Засгийн газар тухай бүр тогтооно.

7.3.Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын үйлчилгээний стандартыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.

8 дугаар зүйл. Төрийн албаны санхүүжилт

8.1.Төрийн албаны зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

8.2.Төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ нь албан хаагчид олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөрийн хэмжээг бууруулах, түр буюу бүрмөсөн зогсоох үндэслэл болохгүй.

8.3.Төрийн албаны санхүүжилт болон төрийн байгууллагын төсвийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг төсвийн тухай болон төрийн аудитын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албаны ангилал болон төрийн албан тушаалын төрөл, төрийн албан хаагч, түүний хувийн хэрэг, тоо бүртгэл

9 дүгээр зүйл. Төрийн албаны ангилал болон төрийн албан тушаалын төрөл

9.1.Төрийн албыг доор дурдсанаар ангилна:

9.1.1.төрийн улс төрийн алба;

9.1.2.төрийн захиргааны алба;

9.1.3.төрийн тусгай алба;

9.1.4.төрийн үйлчилгээний алба.

9.2.Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна.

9.3.Энэ хуулийн 9.1.2, 9.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хөтөлнө.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэл хөтлөх журмыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

9.6.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан төрийн албан хаагчийг энэ хуулийн 9.3-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэнэ.

10 дугаар зүйл. Төрийн албан хаагч

10.1.Дараахь албан тушаалтныг төрийн албан хаагчид хамааруулна:

- 10.1.1.Ерөнхийлөгч;
- 10.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
- 10.1.3.Ерөнхий сайд, сайд, дэд сайд;
- 10.1.4.бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч;
- 10.1.5.Үндсэн хуулийн цэцийн дарга, орлогч дарга, гишүүн;
- 10.1.6.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх нарийн бичгийн дарга;
- 10.1.7.бүх шатны прокурор;
- 10.1.8.Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга;
- 10.1.9.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, дэд дарга;
- 10.1.10.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, дэд дарга;
- 10.1.11.Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд;
- 10.1.12.Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх /орон тооны/;
- 10.1.13.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 10.1.14.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, прокурорын ажлын алба болон шүүхийн захиргааны энэ хуулийн 10.1.6, 10.1.8-10.1.10-т зааснаас бусад удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;
- 10.1.15.яамны Төрийн нарийн бичгийн дарга, яам болон Засгийн газрын агентлаг, түүний дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;
- 10.1.16.бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч;
- 10.1.17.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;
- 10.1.18.Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллага болон түүний ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;
- 10.1.19.аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

10.1.20.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

10.1.21.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалтан;

10.1.22.олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгжийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

10.1.23.хот, тосгоны захирагч болон захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан.

11 дүгээр зүйл. Төрийн улс төрийн албан хаагч

11.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах энэ хуулийн 10.1.1-10.1.3, 10.1.8, 10.1.9, 10.1.12, 10.1.13, 10.1.16, 10.1.17, 10.1.21, 10.1.23-т заасан албан тушаалтан, түүнчлэн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтныг төрийн улс төрийн албан хаагч гэнэ.

11.2.Улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх туслах, хэвлэл мэдээллийн ажилтан нь тухайн албан тушаалтанд шууд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд тухайн байгууллагад харьяалагдана.

12 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагч

12.1.Төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий дараахь албан тушаалтныг төрийн захиргааны албан хаагч гэнэ:

12.1.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, дэд дарга;

12.1.2.яамны Төрийн нарийн бичгийн дарга болон яамны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

12.1.3.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба болон шүүхийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

12.1.4.энэ хуулийн 13.1.3, 13.1.5-д зааснаас бусад Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

12.1.5.энэ хуулийн 13.1.2-т зааснаас бусад Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

12.1.6.хот, тосгоны захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

12.1.7.энэ хуулийн 10.1.19, 10.1.20-д заасан албан тушаалтан.

13 дугаар зүйл. Төрийн тусгай албан хаагч

13.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон бусад тусгай чиг үүрэг бүхий дараахь албан тушаалтныг төрийн тусгай албан хаагч гэнэ:

13.1.1.энэ хуулийн 10.1.4, 10.1.5, 10.1.7, 10.1.11-д заасан албан тушаалтан;

13.1.2.Монголбанкны ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, гишүүн, Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газрын аудитор, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;

13.1.3.зэвсэгт хүчин, цагдаа, гадаадын иргэн, харьяат, хил хамгаалах, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага;

13.1.4.дипломат албан тушаалтан;

13.1.5.зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн.

14 дүгээр зүйл. Төрийн үйлчилгээний албан хаагч

14.1.Төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахь албан тушаалтныг төрийн үйлчилгээний албан хаагч гэнэ:

14.1.1.төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалтан;

14.1.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах болон гүйцэтгэх, туслах албан тушаалтан;

14.1.4.яам, агентлагийн харьяа буюу дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах болон гүйцэтгэх, туслах албан тушаалтан.

14.2.Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

15 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг

15.1.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг /цаашид "хувийн хэрэг" гэх/ нь төрийн албан хаагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, гурван үеийн намтар болон түүний эрхэлсэн албан тушаал, ажлын үр дүнтэй холбогдсон мэдээллийг агуулна.

15.2.Төрийн албан хаагчид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

15.3.Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журмыг Төрийн албаны зөвлөл батална.

16 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл

16.1.Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа болон эрхэлж байсан бүх албан хаагчийн тухай мэдээллийг тусгасан байна.

16.2.Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журмыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа болон төрийн бусад албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв

17 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа

17.1.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

18 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл

18.1.Төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэл гэж ангилна.

18.2.Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

18.3.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

18.4.Ахлах түшмэлийн албан тушаалд яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

18.5.Дэс түшмэлийн албан тушаалд яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

18.6.Туслах түшмэлийн албан тушаалд яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

18.7.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

18.8.Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

19 дүгээр зүйл. Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл

19.1.Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлийг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

20 дугаар зүйл. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл

20.1.Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

21 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв

21.1.Төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан зэрэг дэвийг дараахь албан тушаалтан олгоно:

21.2.1.тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Ерөнхийлөгч;

21.2.2.эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Ерөнхий сайд;

21.2.3.ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан.

21.3.Зэрэг дэв олгохдоо төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзана.

21.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

21.5.Төрийн албаны зарим онцлог салбарын албан тушаалын зэрэг дэвийг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн хуулиар тогтоож болно.

II ХЭСЭГ

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ТАВИХ ШААРДЛАГА БОЛОН
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ЖУРАМ,
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ШАЛГАЛТ**

ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчид тавих шаардлага

22 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавих нийтлэг шаардлага

22.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:

22.1.1.Монгол Улсын иргэн байх;

22.1.2.дээд боловсролтой байх;

Тайлбар: Энэ хуулийн 9.2-т заасан туслах албан тушаалыг хаших төрийн албан хаагчид мөн хуулийн 22.1.2-т заасан шаардлага хамаарахгүй.

22.1.3.Эрүүгийн хуульд заасан онц хүнд болон авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээгүй байх, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дууссан байх;

22.1.4.монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;

22.1.5.сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;

22.1.6.хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх.

Тайлбар: 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд энэ заалт хамаарахгүй.

23 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавих тусгай шаардлага

23.1.Төрийн улс төрийн болон тусгай албан хаагчид тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно.

23.2.Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд томилогдох иргэн энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь тусгай шаардлагыг хангасан байна:

23.2.1.тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 16-гаас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэжлийн багц сургалтад хамрагдаж, амжилттай суралцаж төгссөн байх;

23.2.2.эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэжлийн багц сургалтад хамрагдаж, амжилттай суралцаж төгссөн байх;

23.2.3.ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэжлийн багц сургалтад хамрагдаж, амжилттай суралцаж төгссөн байх.

23.3.Төрийн захиргааны албан хаагчид тавих тусгай шаардлага болон албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, гүйцэтгэх чиг үүргийн цар хүрээг харгалзан Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар албан тушаал тус бүрээр баталж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчид тавих тусгай шаардлага болон албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг батлахдаа холбогдох төсвийн ерөнхийлөн буюу шууд захирагчийн саналыг авсан байна.

23.5.Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.

24 дүгээр зүйл. Мэргэжлийн багц сургалт

24.1.Мэргэжлийн багц сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийн цар хүрээг харгалзан Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

24.2.Мэргэжлийн багц сургалтыг Төрийн удирдлагын академи хариуцан зохион байгуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төрийн албан тушаалд томилох журам

25 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох нийтлэг журам

25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

26 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох үндсэн шалгуур

26.1.Төрийн албан тушаалд иргэнийг томилохдоо чадахуйн зарчим /мерит/-ыг үндсэн шалгуур болгоно.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан шалгуурыг дараахь тохиолдолд хангасанд тооцно:

26.2.1.энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагыг хангасан;

26.2.2.энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон тусгай шаардлагыг хангасан.

26.3.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай шаардлага /ажилласан жилийг тогтоосон/-ын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.

26.4.Албан тушаалд шатлан дэвшүүлэн томилохдоо энэ хуулийн 26.5-д заасан журмыг баримтална.

26.5.Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмыг энэ хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

27 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаалд сонгон шалгаруулж томилох журам

27.1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

27.1.1.төрийн захиргааны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд /карьерын/ шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас буюу энэ хуулийн 9.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс;

27.1.2.төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас буюу холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;

27.1.3.төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс.

27.2.Энэ хуулийн 27.1.1-27.1.3-т заасан тохиолдолд томилох эрх бүхий этгээд ил тод, нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, шалгалт авна.

27.3.Энэ хуулийн 27.2-т заасан тохиолдолд томилох эрх бүхий этгээд тухайн удирдах албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан бөгөөд тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авсан 5 хүртэл төрийн албан хаагчаас нэгийг сонгож, томилно.

28 дугаар зүйл. Төрийн албан тушаалд томилох хугацаа

28.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан тушаалд томилохдоо тодорхой хугацаа заахгүй.

28.2.Хуульд хугацаатай томилохоор заасан төрийн албан тушаалд нөхөн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх албан тушаалтны томилолтын үлдсэн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

28.3.Төрийн албанд анх орсон иргэнд туршилтын хугацааг 6-12 сар хүртэл хугацаагаар тогтоож болно.

28.4.Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журмыг Төрийн албаны зөвлөл батална.

29 дүгээр зүйл. Албан тушаалын ажлын байрны сургалт

29.1.Төрийн албан тушаалд иргэнийг томилсны дараа албан тушаалын ажлын байрны богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Төрийн удирдлагын академи хариуцан зохион байгуулна.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн байгууллага, албан тушаалын онцлог болон гүйцэтгэх чиг үүргийн цар хүрээг харгалзан гаргасан Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын саналыг үндэслэн Төрийн удирдлагын академи тодорхойлно.

30 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналт

30.1.Төрийн албаны зөвлөл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасан үүрэг, даалгаврыг биелүүлээгүй бол Төрийн албаны зөвлөл хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгоно.

31 дүгээр зүйл. Хориглох зүйл

31.1.Төрийн албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно:

31.1.1.энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

31.1.2.төрийн албанаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш төрийн албанд эргэж орох хуульд заасан хугацаа дуусгавар болоогүй;

31.1.3.хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

31.1.4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчил гаргасан үндэслэлээр төрийн албанаас халагдсан өдрөөс хойш 3 жилийн хугацаа дуусгавар болоогүй;

31.1.5.хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.

31.2.Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч болон улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

31.3.Төрийн албан хаагчийг томилох асуудлаар хууль тогтоомж зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

31.4.Монгол Улсын иргэний төрийн албанд ажиллах эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлахыг хориглоно.

32 дугаар зүйл. Хариуцлага

32.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны зөвлөл энэ хуулийн 24, 26-28, 31 дүгээр зүйлд заасныг зөрчсөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас чөлөөлөх мэдэгдлийг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

32.2.Эрх бүхий этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 14 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

32.3.Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон Засгийн газрын томилдог бусад удирдах албан тушаалтныг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчиж томилсон бол холбогдох шийдвэрийг Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгоно.

32.4.Улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс төрийн албан тушаалд томилох үйл явцад аливаа хэлбэрээр нөлөөлсөн тохиолдолд төрийн албан хаагч, төрийн албан тушаалд нэр дэвшигч иргэн энэ тухай тэмдэглэл хөтөлж, холбогдох бүх баримтыг Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор хүргүүлнэ.

32.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны зөвлөл энэ хуулийн 32.4-т заасан тэмдэглэлтэй танилцаад үндэслэлтэй бол холбогдох шийдвэрийг хүчингүй болгоно.

32.6.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч болон улс төрийн албан тушаалтан энэ хуулийн 32.2-т заасныг зөрчсөн тохиолдолд энэ нь тухайн этгээдийг огцруулах үндэслэл болно.

32.7.Энэ хуулийн 32.6-д өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 32.1, 32.2-т заасныг зөрчсөн тохиолдолд энэ нь тухайн эрх бүхий этгээдийг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн шалгалт

33 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн шалгалт

33.1.Төрийн албан хаагчийн шалгалт нь төрийн албан тушаал хаших үндсэн шалгуур болох чадахуйн зарчим /мерит/-ыг тухайн иргэн хангаж байгаа эсэхийг тогтооход чиглэнэ.

33.2.Төрийн албан хаагчийн шалгалт доор дурдсан төрөлтэй байна:

33.2.1.ерөнхий шалгалт;

33.2.2.тусгай шалгалт.

33.3.Төрийн албан хаагчийн нөөцөд бүртгүүлэх иргэнээс ерөнхий шалгалт авна.

33.4.Төрийн албан хаагчийн тусгай шалгалтыг энэ хуулийн 27.1-д заасан тохиолдолд авна.

34 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн шалгалтын хэлбэр, агуулга

34.1.Төрийн албан хаагчийн шалгалт тест, ярилцлага болон бусад хэлбэртэй байна.

34.2.Төрийн албан хаагчийн шалгалт доор дурдсан агуулгатай байна:

34.2.1.удирдан зохион байгуулах чадварыг шалгах;

34.2.2.дүн шинжилгээ хийх чадварыг шалгах;

34.2.3.асуудал шийдвэрлэх чадварыг шалгах;

34.2.4.манлайлах чадварыг шалгах;

34.2.5.монгол хэлний ярианы болон бичгийн чадварыг шалгах;

34.2.6.багаар ажиллах чадварыг шалгах;

34.2.7.бусад.

34.3.Төрийн албан хаагчийн шалгалтын агуулга, хэлбэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн албаны зөвлөл тодорхойлно.

35 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах

35.1.Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг Төрийн албаны зөвлөл цахим болон бусад тохиромжтой хэлбэрээр жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

35.2.Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалт авах тухай олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлэх бөгөөд шалгалтыг төрийн албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэдээс авна.

35.3.Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтад тэнцсэн иргэнийг төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэнэ. Төрийн албан хаагчийн нөөцөд байх хугацаа 3 жил байна.

35.4.Төрийн албаны зөвлөл энэ хуулийн 35.1-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

35.5.Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалт зохион байгуулах журмыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

36 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн тусгай шалгалтыг зохион байгуулах

36.1.Төрийн албан хаагчийн тусгай шалгалтыг доор дурдсан тохиолдолд дараахь этгээд зохион байгуулна:

36.1.1.яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон Засгийн газрын томилдог бусад удирдах албан тушаалд нэр дэвшигчдээс авах тусгай шалгалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;

36.1.2.энэ хуулийн 36.1.1-д зааснаас бусад этгээдээс авах тусгай шалгалтыг тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан этгээд нь тусгай шалгалт авах талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлнэ.

36.3.Энэ хуулийн 36.1-д заасан этгээд нь тусгай шалгалт авахдаа холбогдох байгууллага болон мэргэжлийн холбоо, эрдэмтэн, судлаачдын төлөөллөөс бүрдсэн Шалгалтын зөвлөл байгуулна.

36.4.Төрийн албан хаагчийн тусгай шалгалт зохион байгуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

37 дугаар зүйл. Хориглох зүйл

37.1.Төрийн албан хаагчийн шалгалт авах журмыг зөрчих болон уг үйл ажиллагаатай холбогдсон хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

38 дугаар зүйл. Хариуцлага

38.1.Төрийн албан хаагчийн шалгалт авах журмыг зөрчсөн тохиолдолд тухайн шалгалтын дүнг хүчингүй болгож, гэм буруутай төрийн албан хаагчийг төрийн албанд 5 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална.

38.2.Төрийн албан хаагчийн шалгалт авах журмыг зөрчсөн энэ хуулийн 36.3-т заасан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох бөгөөд Шалгалтын зөвлөлийн бүрэлдэхүүнд дахин оруулахгүй.

38.3.Энэ хуулийн 38.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанд 5 жилийн хугацаанд эргэж орох эргүйгээр төрийн албанаас хална.

38.4.Энэ хуулийн 37.1-д заасныг зөрчиж, хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргасан төрийн албан хаагчийг төрийн албанд 5 жилийн хугацаанд эргэж орох эргүйгээр төрийн албанаас хална.

III ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ, НИЙТЛЭГ ҮҮРЭГ, ЭРХ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ, ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

НАЙМДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн тангараг

39 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн тангараг

39.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн төрийн албанд анх орохдоо: "Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" хэмээн тангараг өргөж баталгаажуулна.

39.2.Тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйл

40 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг

40.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

40.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

40.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

40.1.3.эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

40.1.4.улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс татгалзаж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа байгууллагын захиргаа болон харьяалах нам, Төрийн албаны зөвлөлд бичгээр албан ёсоор мэдэгдэх;

40.1.5.харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

40.1.6.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

40.1.7.өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хууль тогтоомжийг судалж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

40.1.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

40.1.9.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

40.1.10.төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээлэх;

40.1.11.иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

40.1.12.ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах;

40.1.13.удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

40.1.14.харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;

40.1.15.Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах;

40.1.16.үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх;

40.1.17.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

41 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг эрх

41.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг эрх эдэлнэ:

41.1.1.ажлын байранд тавигдах шаардлага болон ажиллах нөхцөл, албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолттой тухайн албан тушаалд томилогдмогц албан ёсоор танилцах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;

41.1.2.гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхийг харьяалах дээд шатны удирдах ажилтнаас шаардах, үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

41.1.3.цалин хөлсөө нэмэгдүүлэх, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан хаагчид бичгээр тавих;

41.1.4.өөрийн хувийн хэрэг болон түүнд оруулах ажил байдлын тодорхойлолт зэрэг материалтай танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгтээ нэмэлт тайлбар хийх;

41.1.5.өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах;

41.1.6.байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

41.1.7.хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох;

41.1.8.төрийн албанаас чөлөөлөгдөх;

41.1.9.мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодод сургалтад хамрагдах;

41.1.10.хууль тогтоомжид заасан бусад эрх.

42 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

42.1.Төрийн албан хаагч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

42.1.1.бусад шатны албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах;

42.1.2.албаны эрх мэдлээ хэтрүүлэх;

42.1.3.хуульд нийцээгүй шийдвэр гаргах;

42.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусад хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах;

42.1.5.улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;

42.1.6.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах;

42.1.7.ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

42.1.8.албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

42.1.9.Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;

42.1.10.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

42.1.11.албаны бус зорилгод байгууллагынхаа эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;

42.1.12.Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 4.1.5, 4.1.6, 6.4-т заасан жендэрийн шууд ба шууд бус хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах;

42.1.13.хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгсэл /facebook, twitter болон бусад/-ийг ашиглан улс төрийн үзэл

бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх;

42.1.14.төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараах;

42.1.15.хууль тогтоомжид заасан бусад.

Тайлбар: Энэ хуулийн 42.1.5, 42.1.6, 42.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй.

43 дугаар зүйл. Хариуцлага

43.1.Энэ хуулийн 40.1-д заасан үүргээ биелүүлээгүй албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан мөн хуулийн 50.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

43.2.Энэ хуулийн 41.1-д заасан эрхийг зөрчсөн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр шүүх торгоно.

43.3.Энэ хуулийн 42.1.1-42.1.4-т заасныг зөрчсөн албан хаагчийг 3-5 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр, 42.1.5, 42.1.6-д заасныг зөрчсөн албан хаагчийг 1-3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр тус тус төрийн албанаас хална.

43.4.Энэ хуулийн 42.1.7-42.1.15-д заасныг зөрчсөн албан хаагчийг тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулах, эсхүл төрийн албанд 1-3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална.

АРАВДУГААР БҮЛЭГ

Ёс зүйн хэм хэмжээ

44 дүгээр зүйл. Ёс зүйн хэм хэмжээ

44.1.Төрийн албан хаагч дараахь ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

44.1.1.албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу олон нийтийн өмнө согтууруулах ундаа хэрэглэхгүй байх;

44.1.2.танхайрах, бусдыг айлган сүрдүүлэх, хүч хэрэглэхгүй байх;

44.1.3.бусдын эд хөрөнгийг эвдэж сүйтгэх, ашиглах боломжгүй болгох зэргээр зүй зохисгүй, бүдүүлэг үйлдэл гаргахгүй байх;

44.1.4.ажлын байрандаа тэсэрч дэлбэрэх, галын аюултай гэх мэт зөвшөөрөгдөөгүй материал хадгалах, эзэмшихгүй байх;

44.1.5.албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа албан бус байдлаар хувцаслахгүй байх;

Тайлбар: Энэ хуулийн 44.1.5-д заасан хязгаарлалтад монгол дээл болон үндэсний хувцас хамаарахгүй.

44.1.6.ажлын цагаар бусдад саад болж, шалтгаангүйгээр ажлыг нь тасалдуулахгүй байх, ажлын өрөө, орчин руу зөвшөөрөлгүй нэвтрэхгүй байх;

44.1.7.ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх өнгө аяс бүхий захиа, дүрс илгээх, дамжуулахгүй байх;

44.1.8.бусдын мэдээллийн технологийн техник, хэрэгслийн нууц үгийг зөвшөөрөлгүйгээр хэрэглэх, хаах, өөрчлөхгүй байх;

44.1.9.байгууллагын программ хангамж, цахим мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, зөөвөрлөхгүй байх;

44.1.10.зохиогчийн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй байх;

44.1.11.садар самуун явдлыг харуулсан материалыг үзэх, солилцохгүй байх;

44.1.12.бусдын нэр хүндийг гутаах, гүжир гүтгэлгийн чанартай захидал илгээх, дамжуулахгүй байх;

44.1.13.бизнесийн үйл ажиллагаатай холбоотой сүлжээ захиа, шаардлага, зар сурталчилгаа илгээх, дамжуулахгүй байх;

44.1.14.хууль тогтоомжид заасан бусад.

45 дугаар зүйл. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

45.1.Энэ хуулийн 44.1.1-44.1.4-т заасныг зөрчсөн албан хаагчид мөн хуулийн 53.1.2-53.1.4-т заасан сахилгын шийтгэл ногдуулна.

45.2.Энэ хуулийн 45.1-д зааснаас бусад тохиолдолд ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагчид мөн хуулийн 53.1-д заасан сахилгын шийтгэл ногдуулна.

45.3.Энэ хуулийн 45.2, 45.3-т заасан албан хаагч үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргавал түүнийг сахилгын шийтгэлээс чөлөөлнө. Энэ нь тухайн албан хаагчийг захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

45.4.Төрийн байгууллага энэ хуулийн 44.1-д заасан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдүүлэн байнгын хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

45.5.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд тухайн төрийн байгууллагын удирдлага, олон нийт болон Төрийн албаны зөвлөл хяналт тавина.

45.6.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг тухайн байгууллагын удирдлагад гаргана.

45.7.Энэ хуулийн 45.6-д заасан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг Төрийн албаны зөвлөл батална.

IV ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

46 дугаар зүйл. Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа

46.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэний төрийн алба хаах эрх 18 нас хүрснээр үүснэ.

46.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэр авах эрх эмэгтэй бол 55 нас, эрэгтэй бол 60 нас хүрснээр тус тус үүснэ. Төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.

46.3.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

47 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл

47.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно:

47.1.1.ээлжийн амралттай;

47.1.2.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй;

47.1.3.дотоод, гадаад албан томилолттой;

47.1.4.зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан;

47.1.5.удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тусгай даалгавар, ажил үүрэг гүйцэтгэж байгаа;

47.1.6.жирэмсний болон амаржсаны амралттай;

47.1.7.албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан;

47.1.8.албан хаагчийг өөр албан тушаалд сонгосон буюу томилсон;

47.1.9.албан хаагч нас барсан.

48 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам

48.1.Энэ хуулийн 48.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан гаргана.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан шийдвэрт албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацааг заах бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх чиг үүрэг, эрх хэмжээг тусгайлан зааж болно.

48.3.Төрийн албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ:

48.3.1.байгууллагын даргын албан үүргийг түүний дэд дарга, орлогч түр орлон гүйцэтгэх бөгөөд энэ тохиолдолд тусгайлан шийдвэр гаргахгүй.

48.3.2.дэд дарга, орлогчгүй, эсхүл тэд орлох боломжгүй бол байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх;

48.3.3.энэ хуулийн 48.3.1, 48.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

48.3.4.жирэмсний болон амаржсаны амралттай, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон авч, хугацаа заан түр орлон гүйцэтгүүлэх.

48.4.Энэ хуулийн 48.2-т өөрөөр заагаагүй бол албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь түр орлон гүйцэтгэх хугацаандаа тухайн түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

48.5.Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна.

48.6.Энэ хуулийн 48.5-д өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид үндсэн албан тушаалын цалин дээр нэмж тухайн түр орлон гүйцэтгэсэн албан тушаалын цалинг олгоно.

48.7.Энэ хуулийн 48.3.1-д заасны дагуу байгууллагын даргын албан үүргийг түүний дэд дарга, орлогч түр орлон гүйцэтгэх тохиолдолд түүнд мөн хуулийн 48.6 дахь хэсэг хамаарахгүй.

48.8.Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно.

49 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

49.1.Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачлагаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно.

Тайлбар: Энэ хуулийн 49.1-д заасан албан ажлын зайлшгүй шаардлага гэдэгт тухайн байгууллагад шаардлагатай байгаа мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг нөхцөл, байдлыг ойлгоно.

49.2.Энэ хуулийн 49.3-т өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага буюу тухайн байгууллагын нэгж хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

49.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 49.1, 49.2-т заасны дагуу төрийн албан хаагчийг сэлгэн буюу шилжүүлэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг, дэвийг бууруулахгүй.

49.4.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 49.2-т заасан албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь шууд үргэлжлүүлэн ажиллуулна.

49.5.Төрийн албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах журмыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

50 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас нь бууруулах

50.1.Төрийн албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар албан тушаал бууруулж болно:

50.1.1.хууль тогтоомж болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;

50.1.2.үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон;

50.1.3.хуульд заасан бусад үндэслэл.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч гаргана.

51 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх, чөлөөлөх

51.1.Төрийн албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар түр чөлөөлнө:

51.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 3 сараас дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;

51.1.2.зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон;

51.1.3.цэргийн жинхэнэ алба хаах болсон.

51.2.Төрийн албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар чөлөөлнө:

51.2.1.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон;

51.2.2.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

51.2.3.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

51.2.4.өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

51.2.5.хуульд заасан бусад үндэслэл.

51.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаарт хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачлагаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

51.4.Төрийн албан хаагч нь Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө,

ээлжит бус сонгуульд нэр дэвших бол тухайн сонгууль болохоос 60 хоногийн өмнө, нөхөн, дахин сонгуульд нэр дэвших бол тухайн сонгууль болохоос 30 хоногийн өмнө тус тус төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө байгууллагынхаа эрх бүхий албан хаагчид буюу томилсон эрх бүхий байгууллагад гаргана. Төрийн албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн байгууллага түүнийг чөлөөлөхөд саад болохгүй.

51.5.Энэ хуулийн 51.1, 51.2-т заасан шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч гаргана.

51.6.Энэ хуулийн 51.1, 51.2.1, 51.2.4-т заасан иргэнийг төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцно.

52 дугаар зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаалаас нь халах

52.1.Төрийн албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас хална:

52.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /3 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн;

52.1.2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

52.1.3.Монгол Улсын харьяатаас гарсан;

52.1.4.энэ хуульд заасан бусад үндэслэл.

52.2.Энэ хуулийн 52.1-д заасан шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч гаргана.

53 дугаар зүйл. Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

53.1.Хуульд өөрөөр заагаагүй бол албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

53.1.1.сануулах;

53.1.2.албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

53.1.3.төрийн албанаас халах;

53.1.4.төрийн албанд 1-5 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

53.1.5.энэ хуульд заасан бусад.

53.2.Энэ зүйлийн 53.1-д заасан сахилгын шийтгэлийг дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.

53.3.Төрийн албан хаагчид түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтны буюу хамтын удирдлага бүхий байгууллага томилсон бол тухайн байгууллагын даргын шийдвэрээр тус тус сахилгын шийтгэл ногдуулна.

53.4.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 36 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

53.5.Сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.

53.6.Төрийн албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

53.7.Энэ хуульд заасныг зөрчсөн төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

53.8.Төрийн албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор Төрийн албаны зөвлөлд гаргаж болно.

53.9.Сахилгын шийтгэлийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх журмыг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран батална.

54 дүгээр зүйл. Хориглох зүйл

54.1.Төрийн албан хаагчийг хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халахыг хориглоно.

55 дугаар зүйл. Хариуцлага

55.1.Төрийн албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг Төрийн албаны зөвлөл буюу шүүх тогтоосон бол түүний ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 55.2-т өөрөөр заагаагүй бол уг хууль бус шийдвэрийг гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

55.2.Энэ хуулийн 55.1-д заасан хууль бус шийдвэрийг гаргасан этгээд Засгийн газар бол мөн хэсэгт заасан ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Ерөнхий сайдаар нөхөн төлүүлнэ.

55.3.Энэ хуулийн 55.1-д заасан үүргийг 30 хоногийн дотор биелүүлээгүй албан тушаалтныг төрийн албанд 5 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халж, нөхөн төлбөрийг шүүхийн журмаар нэхэмжлэн гаргуулна.

55.4.Ерөнхий сайд энэ хуулийн 55.2-т заасан үүргийг 30 хоногийн дотор биелүүлээгүй бол нөхөн төлбөрийг шүүхийн журмаар нэхэмжлэн гаргуулах бөгөөд энэ нь түүнийг огцруулах үндэслэл болно.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шагнал, мөнгөн урамшуулал

56 дугаар зүйл. Шагнал, мөнгөн урамшуулал

56.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж, хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна:

56.1.1.Эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах;

56.1.2.Монгол Улсын цол хүртээх, төрийн дээд одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх;

56.1.3.Засгийн газар болон бусад төрийн байгууллагын шагналд тодорхойлох.

56.2.Энэ хуулийн 56.1.1-д заасан шагнал олгох болон 56.1.3-т заасан шагналд тодорхойлох журмыг Засгийн газар, 56.1.2-т заасан шагналд нэр дэвшүүлэх журмыг Ерөнхийлөгч тус тус батална.

V ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

57 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх нийтлэг үндэслэл

57.1.Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

57.2.Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

58 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд баримтлах зарчим

58.1.Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зарчмыг баримтална:

58.1.1.Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажиллагаа болон холбогдох тайлан, дүгнэлт ил тод, нээлттэй байх;

58.1.2.Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажиллагаа тоо баримт, судалгаа, мэдээлэлд үндэслэсэн, тухайн хөтөлбөр, арга хэмжээний үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлсон, хэмжигдэхүйц, нотлогдохуйц байх;

58.1.3.Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажиллагааг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

58.1.4.Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажиллагаа хараат бус, бие даасан байх;

58.1.5.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажиллагаа тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй уялдсан байх.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Стратеги төлөвлөгөө

59 дүгээр зүйл. Стратеги төлөвлөгөө

59.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн харьяа байгууллагын стратеги төлөвлөгөө /цаашид "стратеги төлөвлөгөө" гэх/-г 4 жилийг хамруулан боловсруулж, хэрэгжилтийг нь хариуцан зохион байгуулна.

59.2.Стратеги төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгана:

59.2.1.тухайн байгууллагын эрхэм зорилго;

59.2.2.тухайн байгууллагын үндсэн зорилго, зорилт;

59.2.3.тухайн байгууллагын үндсэн зорилго, зорилтод хүрэх үе шат, арга хэрэгсэл /шаардлагатай хүний болон хөрөнгө санхүү, мэдээллийн нөөц, техник хэрэгсэл/;

59.2.4.тухайн байгууллага үндсэн зорилго, зорилтоо хангахад сөргөөр нөлөөлж болох гадаад хүчин зүйл.

59.3.Байгууллагын эрхэм зорилго, үндсэн зорилго, зорилтыг хууль тогтоомжийн дагуу тухайн байгууллагын хэрэгжүүлж байгаа үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг бүрэн хамруулан тодорхойлно.

60 дугаар зүйл. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах

60.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, цаг үеийн шаардлагыг харгалзан стратеги төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

60.2.Энэ хуулийн 60.1-д заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар ажлын 5 өдрийн дотор Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд мэдэгдэнэ.

61 дүгээр зүйл. Стратеги төлөвлөгөөний төслийн талаар санал авах

61.1.Стратеги төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо болон олонхи, цөөнхийн Бүлэгт хүргүүлж, санал авсан байна.

61.2.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо болон олонхи, цөөнхийн Бүлэг нь энэ хуулийн 61.1-д заасан төлөвлөгөөний төслийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор саналаа төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

61.3.Стратеги төлөвлөгөөг боловсруулах үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, санал авсан байна.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө

62 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө

62.1.Засгийн газар тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

62.2.Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг энэ хуулийн 62.1-д заасан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулна.

62.3.Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд дараахь асуудлыг тусгана:

62.3.1.энэ хуулийн 63.3.2-т заасан тэргүүлэх зорилтоос сонгосон Засгийн газрын тэргүүлэх зорилт;

62.3.2.хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон гүйцэтгэлийн зорилт;

62.3.3.хөтөлбөр, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны нэр;

62.3.4.гүйцэтгэлийн зорилтод хүрэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт;

62.3.5.хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ;

62.3.6.хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд.

62.4.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлт /тоо, хэмжээ, цаг хугацаа/-ээр тогтооно.

62.5.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тусгана.

62.6.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллана.

63 дугаар зүйл. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

63.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан, хариуцсан хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

63.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь энэ хуулийн 59.1-д заасан стратеги төлөвлөгөөтэй уялдсан байна.

63.3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгана:

63.3.1.тухайн байгууллагын төсөвт тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон гүйцэтгэлийн зорилт;

63.3.2.нийгэм, эдийн засгийн ач холбогдлын хувьд тэргүүлэх ач холбогдол өгч, хэрэгжүүлэх 5 хүртэлх хөтөлбөр, арга хэмжээг хамарсан тэргүүлэх зорилт;

63.3.3.гүйцэтгэлийн зорилтод хүрэх үе шат, арга хэрэгсэл /шаардлагатай хүний болон хөрөнгө санхүү, мэдээллийн нөөц, техник хэрэгсэл/;

63.3.4.хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд;

63.3.5.хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллага, албан тушаалтны нэр.

63.4.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлт /тоо, хэмжээ, цаг хугацаа/-ээр тогтооно.

63.5.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тусгана.

64 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

64.1.Төрийн албан хаагч нь хууль тогтоомж болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

64.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүнчлэн төрийн албан хаагчийн харьяалагддаг нэгжийн чиг үүрэг, зорилттой уялдсан байна.

64.3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгана:

64.3.1.тухайн жилд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон гүйцэтгэлийн зорилт;

64.3.2.гүйцэтгэлийн зорилтод хүрэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт;

64.3.3.гүйцэтгэлийн зорилтод хүрэх үе шат, арга хэрэгсэл /шаардлагатай хөрөнгө санхүү, мэдээллийн нөөц, техник хэрэгсэл/;

64.3.4.гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллага, албан тушаалтны нэр;

64.3.5.үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд.

64.4.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлт /тоо, хэмжээ, цаг хугацаа/-ээр тогтооно.

64.5.Гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тусгана.

64.6.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох төсвийн шууд захирагч батална.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

65 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайлан

65.1.Засгийн газар гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайланг доор дурдсан хугацаанд бэлтгэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

65.1.1.улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

65.1.2.жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор.

65.2.Тайланд тухайн хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг батлагдсан гүйцэтгэлийн зорилттой харьцуулан тайлагнасан байна.

65.3.Тайланд дараахь асуудлыг тусгана:

65.3.1.энэ хуулийн 65.1.1-д заасан улирлын тайланд гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан ажил, үйлчилгээний явц, үр дүн /тухайлбал,

хэрэгжилтийг зохион байгуулахад гарч байгаа бэрхшээл, саад, тэдгээрийг хэрхэн даван туулж байгаа, санхүүгийн, хүний болон бусад нөөцийг хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаа тухай/;

65.3.2.энэ хуулийн 65.1.2-т заасан жилийн эцсийн тайланд гүйцэтгэлийн зорилтыг хангасан эсэх тухай дүгнэлт;

65.3.3.төлөвлөсөн үр дүнд хүрээгүй хөтөлбөр, арга хэмжээ байгаа бол түүний шалтгаан, нөхцөл;

65.3.4.энэ хуулийн 65.3.3-т заасан тохиолдолд үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар цаашид авах арга хэмжээний санал.

66 дугаар зүйл. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

66.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг доор дурдсан хугацаанд бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ:

66.1.1.улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор;

66.1.2.жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор.

66.2.тайлан нь энэ хуулийн 65.2, 65.3-т заасан шаардлагыг хангасан байна.

67 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

67.1.Төрийн албан хаагч нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг доор дурдсан хугацаанд бэлтгэж, холбогдох төсвийн шууд захирагчид цахим хэлбэрээр хүргүүлнэ:

67.1.1.улирлын тайланг дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор;

67.1.2.жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор.

67.2.Тайланд тухайн ажил, үйлчилгээний явцыг батлагдсан гүйцэтгэлийн зорилттой харьцуулан тайлагнасан байна.

67.3.Тайланд дараахь асуудлыг тусгана:

67.3.1.гүйцэтгэлийн зорилтыг хангасан эсэх тухай дүгнэлт;

67.3.2.төлөвлөсөн үр дүнд хүрээгүй ажил, үйлчилгээ байгаа бол түүний шалтгаан, нөхцөл;

67.3.3.энэ хуулийн 67.3.2-т заасан тохиолдолд үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар цаашид авах арга хэмжээний санал.

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ

Аудит

68 дугаар зүйл. Аудит хийх

68.1.Энэ хуулийн 65-67 дугаар зүйлд заасан тайланд доор дурдсан байгууллага, албан тушаалтан аудит хийнэ:

68.1.1.Засгийн газрын гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайланд Үндэсний аудитын газар;

68.1.2.байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж/;

68.1.3.төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд холбогдох төсвийн шууд захирагч /хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж/.

69 дүгээр зүйл. Аудитын ангилал, зорилго

69.1.Энэ хуулийн 68.1-д заасан аудитыг доор дурдсан байдлаар ангилна:

69.1.1.улирлын тайланд хийх аудит;

69.1.2.жилийн эцсийн тайланд хийх аудит.

69.2.Төлөвлөгөөнд тусгасан ажил, үйлчилгээний явц, үр дүн /тухайлбал, хэрэгжилтийг зохион байгуулахад гарч байгаа бэрхшээл, саад, тэдгээрийг хэрхэн даван туулж байгаа, санхүүгийн, хүний болон бусад нөөцийг хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаа/-г шалгаж, цаашид үйл ажиллагааг нь сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргахад энэ хуулийн 69.1.1-д заасан аудитын зорилго оршино.

69.3.Төлөвлөгөөнд тусгасан ажил, үйлчилгээний биелэлтийг батлагдсан гүйцэтгэлийн зорилттой харьцуулан эцсийн байдлаар шалгаж, дүгнэхэд энэ хуулийн 66.1.2-т заасан аудитын зорилго оршино.

70 дугаар зүйл. Аудитын дүгнэлт

70.1.Энэ хуулийн 68.1-д заасан байгууллага гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд аудит хийж, дүгнэлт гаргана.

70.2.Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Үндэсний аудитын газар 14 хоногийн дотор Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанд оруулж танилцуулна.

70.3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 14 хоногийн дотор Засгийн газрын хуралдаанд оруулж танилцуулна.

70.4.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хийсэн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч 14 хоногийн дотор холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Олон нийтийн хяналт

71 дүгээр зүйл. Олон нийтийн хяналт

71.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлнэ.

71.2.Энэ хуулийн 71.1-д заасан байгууллагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгоно.

71.3.Энэ хуулийн 71.2-т заасан сонгон шалгаруулалтын журмыг мөн хуулийн 73.1-д заасан Олон нийтийн хяналтын зөвлөл батална.

72 дугаар зүйл. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх

72.1.Энэ хуулийн 71.1-д заасан байгууллага жилд 3-аас доошгүй яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг шалгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

72.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлнэ.

72.3.Хэрэглэгчийн үнэлгээг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн, эсхүл аж ахуйн нэгжүүдийн 3-5 хувийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана.

72.4.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд тавих олон нийтийн хяналтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Олон нийтийн хяналтын зөвлөлийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.

72.5.Удирдамжид дараахь зүйлийг тусгана:

72.5.1.он, сар, өдөр, удирдамжийн нэгдсэн дугаар;

72.5.2.хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл;

72.5.3.хяналт-шинжилгээ, үнэлгээний төрөл, арга, хэлбэр;

72.5.4.хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллагын нэр;

72.5.5.хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагчийн нэр;

72.5.6.хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил эхлэх, дуусах хугацаа.

73 дугаар зүйл. Олон нийтийн хяналтыг санхүүжүүлэх

73.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

73.2.Энэ хуулийн 73.1-д заасан хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсөвт тусгана.

74 дүгээр зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөл

74.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг Олон нийтийн хяналтын зөвлөл зохион байгуулна.

74.2.Олон нийтийн хяналтын зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

74.2.1.энэ хуулийн 73.1-д заасан хөрөнгийг захиран зарцуулах;

74.2.2.олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах;

74.2.3.энэ хуулийн 74.2.2-т заасан байгууллагатай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.

74.3.Олон нийтийн хяналтын зөвлөл чиг үүргээ Засгийн газраас хараат бусаар хэрэгжүүлнэ.

75 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн

75.1.Олон нийтийн хяналтын зөвлөл нь 9 гишүүнтэй байна. Зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос 3 жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг улируулан сонгохгүй.

75.2.Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг нийгэмд үйлчилдэг Засгийн газрын бус байгууллагын төлөөллөөс бүрдүүлнэ.

75.3.Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

76 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм

76.1.Олон нийтийн хяналтын зөвлөл нь дүрэмтэй байна.

76.2.Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

77 дугаар зүйл. Олон нийтийн хяналтын зөвлөлийн тайлан

77.1.Олон нийтийн хяналтын зөвлөл нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа улирал тутам Үндэсний аудитын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтоосон хугацаанд ирүүлж байна.

77.2.Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргана.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

78 дугаар зүйл. Засгийн газрын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

78.1.Засгийн газар гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг энэ хуулийн 70.1-д заасан аудитын дүгнэлт, 72.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлэх бөгөөд Байнгын хороо хуралдаанаараа 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэж, дүгнэлт гаргана.

78.2.Улсын Их Хурлын Байнгын хороогоор гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг хэлэлцэхдээ гүйцэтгэлийн зорилтын биелэлт тус бүрийг хэлэлцэнэ.

78.3.Энэ хуулийн 78.1-д заасан дүгнэлтэд дараахь шийдвэрийн аль нэгийг тусгана:

78.3.1.гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө бүрэн биелсэн буюу тухайн төлөвлөгөөний биелэлт 90-100 хувьтай бол ажлын гүйцэтгэл “сайн” гэсэн үнэлгээ өгөх;

78.3.2.гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний биелэлт 60-90 хувьтай бол гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж, чиглэл өгөх;

78.3.3.гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний биелэлт 60-аас доош хувьтай бол холбогдох байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг Засгийн газарт өгөх.

79 дүгээр зүйл. Байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

79.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор дүгнэж, доор дурдсан үнэлгээ өгнө:

79.1.1.тухайн төлөвлөгөөний биелэлт 90-100 хувьтай бол ажлын гүйцэтгэл, үр дүн “А”;

79.1.2.тухайн төлөвлөгөөний биелэлт 80-90 хувьтай бол ажлын гүйцэтгэл, үр дүн “В”;

79.1.3.тухайн төлөвлөгөөний биелэлт 70-80 хувьтай бол ажлын гүйцэтгэл, үр дүн “С”;

79.1.4.тухайн төлөвлөгөөний биелэлт 50-70 хувьтай бол ажлын гүйцэтгэл, үр дүн “D”;

79.1.5.тухайн төлөвлөгөөний биелэлт 50-аас доош хувьтай бол ажлын гүйцэтгэл, үр дүн “F”.

80 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх

80.1.Төсвийн шууд захирагч нь төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дараа жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор дүгнэж, энэ хуулийн 79.1-д заасан аргачлалын дагуу үнэлгээ өгнө.

80.2.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж, хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд “А” үнэлгээ өгч болно.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, түүний ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

81 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх үндэслэл

81.1.Төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

82 дугаар зүйл. Төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

82.1.Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

82.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “А”, “В” үнэлгээтэй байгууллагын төсвийн шууд захирагчид урамшуулал олгоно.

82.3.Энэ хуулийн 82.2-т заасан урамшууллын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

82.4.Энэ хуулийн 82.2-т заасан урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн багцад тусгаж батална.

83 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал

83.1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “А”, “В” үнэлгээтэй төрийн албан хаагчид урамшуулал олгоно.

82.2.Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

83.3.Энэ хуулийн 83.2-т заасан урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн багцад тусгаж батална.

83.4.Энэ хуулийн 83.1-д заасан төрийн албан хаагчийг мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулна.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хариуцлага

84 дүгээр зүйл. Төсвийн шууд захирагчид хүлээлгэх хариуцлага

84.1.Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D”, “F” үнэлгээтэй байгууллагын төсвийн шууд захирагчид дараахь хариуцлага хүлээлгэнэ:

84.1.1.гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D” үнэлгээтэй бол албан тушаалын нэг сарын цалинг гурван сар хүртэл хугацаагаар 5-10 хувь хүртэл бууруулах;

84.1.2.гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “F” үнэлгээтэй бол албан тушаалын нэг сарын цалинг гурван сар хүртэл хугацаагаар 15-20 хувь хүртэл бууруулах.

84.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D”, “F” үнэлгээ хоёр жил дараалан авсан төсвийн шууд захирагчийг албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн гэж үзэн албан тушаал бууруулах, эсхүл тохиромжтой албан тушаалд шилжүүлэх арга хэмжээ авна.

84.3.Энэ хуулийн 84.1, 84.2-т заасан шийдвэрийг тухайн төсвийн шууд захирагчийг томилх, чөлөөлөх эрх бүхий этгээд гаргана.

85 дугаар зүйл. Төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлага

85.1.Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D”, “F” үнэлгээтэй төрийн албан хаагчид дараахь хариуцлага хүлээлгэнэ:

85.1.1.гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D” үнэлгээтэй төрийн албан хаагчийн албан тушаалын нэг сарын цалинг гурван сар хүртэл хугацаагаар 5-10 хувь хүртэл бууруулах;

85.1.2.гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “F” үнэлгээтэй төрийн албан хаагчийн албан тушаалын нэг сарын цалинг гурван сар хүртэл хугацаагаар 15-20 хувь хүртэл бууруулах.

85.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд “D”, “F” үнэлгээ хоёр жил дараалан авсан төрийн албан хаагчийг тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд дараахь арга хэмжээний аль нэгийг авна:

85.2.1.албан тушаал бууруулах;

85.2.2.тохирох албан тушаалд шилжүүлэх;

85.2.3.ажлаас халах.

85.3.Энэ хуулийн 85.1, 85.2-т заасан шийдвэрийг холбогдох төсвийн шууд захирагч гаргана.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах арга хэмжээ

86 дугаар зүйл. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах төлөвлөгөө

86.1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт “D”, “F” үнэлгээтэй байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор Засгийн газар холбогдох төсвийн шууд захирагчид зөвлөмж, чиглэл өгнө.

86.2.Гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний биелэлт “D”, “F” үнэлгээтэй байгууллагын төсвийн шууд захирагч үйл ажиллагааныхаа үр дүнг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

86.3.Энэ хуулийн 86.2-т заасан төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, үнэлэхэд мөн хуулийн 66, 79, 84 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

87 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах арга хэмжээ

87.1.Төсвийн шууд захирагч гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь “D”, “F” үнэлгээтэй төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

87.1.1.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

87.1.2.төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, чадавхийг дээшлүүлэх зорилгоор богино болон дунд хугацааны сургалтад хамруулах;

87.1.3.шаардлагатай бусад арга хэмжээ.

87.2.Төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 87.1-д заасан арга хэмжээний тайланг тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гүйцэтгэлийн нэгдсэн сан

88 дугаар зүйл. Гүйцэтгэлийн нэгдсэн сан

88.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гүйцэтгэлийн нэгдсэн санг цахим хэлбэрээр үүсгэн, нийтэд ил тод, нээлттэй ажиллуулна.

88.2.Эрх бүхий этгээд гүйцэтгэлийн нэгдсэн сангийн цахим хуудсанд доор дурдсан баримт бичгийг батлагдсанаас буюу гаргаснаас нь хойш 3 хоногийн дотор ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилж байна:

88.2.1.энэ хуулийн 59.1, 62.1, 63.1, 64.1, 86.2, 87.1.1-д заасан төлөвлөгөө;

88.2.2.энэ хуулийн 65.1, 66.1, 67.1, 77.1-д заасан тайлан;

88.2.3.энэ хуулийн 70.1, 78.1-д заасан дүгнэлт;

88.2.4.энэ хуулийн 78.3-т заасан шийдвэр;

88.2.5.энэ хуулийн 79.1, 80.1, 80.2-т заасан үнэлгээ;

88.2.6.энэ хуулийн 86.1-д заасан зөвлөмж, чиглэл.

Тайлбар: “Тухай бүр шинэчилж байна” гэснийг тухайн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл баримт бичиг бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд уг баримт бичгийг 3 хоногийн дотор шинэчлэхийг ойлгоно.

Тайлбар: “Эрх бүхий этгээд” гэснийг тухайн баримт бичгийг баталсан буюу гаргасан байгууллага, албан тушаалтныг ойлгоно.

88.3.Энэ хуулийн 88.2-т заасан баримт бичгийг гүйцэтгэлийн нэгдсэн сангийн цахим хуудсанд байршуулахдаа холбогдох зураг болон шаардлагатай бусад баримтыг хавсаргасан байна.

88.4.Энэ хуулийн 88.2-т заасан баримт бичгийг цахим хэлбэрт оруулж, гүйцэтгэлийн нэгдсэн сангийн цахим хуудсанд байршуулах, санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах, түүний байнгын, тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

VI ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС, НӨХӨХ ТӨЛБӨР, ТУСЛАМЖ БОЛОН НИЙГМИЙН БАТАЛГАА

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн албан хаагчид олгох цалин хөлс

89 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн цалин хөлс

89.1.Хууль болон ажлын байрны тодорхойлолтод заасан албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрийн албан хаагчид төрөөс цалин хөлс олгоно.

89.2.Төрийн албан хаагчийн цалин хөлс нь:

89.2.1.улс төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;

89.2.2.захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, зэрэг, дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс;

89.2.3.тусгай албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын болон мэргэшлийн зэргийн нэмэгдлээс;

89.2.4.үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

89.3.Төрийн улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг Төрийн албаны зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

89.4.Доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно:

89.4.1.сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;

89.4.2.төрийн захиргааны албан хаагч;

89.4.3.зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан;

89.4.4.дипломат албан хаагч;

89.4.5.үйлчилгээний албан хаагч;

89.4.6.улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан.

89.5.Төрийн улс төрийн албан хаагч болон Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Монголбанкны ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн

бичгийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн хууль тогтоомжоор тогтооно.

89.6.Энэ хуулийн 89.4-т заасан төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам, хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

89.7.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

89.8.Энэ хуулийн 89.7-д заасан албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч хамаарахгүй.

89.9.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлж цагаар тооцож болно. Цалин хөлсийг цагаар тооцох ажлын байрны жагсаалтыг Засгийн газар тогтооно.

90 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох

90.1.Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтооход дараахь журмыг баримтална:

90.1.1.ажлын байрны шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн байгууллагын үйл ажиллагааны зохих хүрээ, албан тушаалын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг үндэслэн боловсруулж мөрдүүлэх;

90.1.2.цалингийн хэмжээ нь нийгмийн амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байх;

90.1.3.Дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа дипломат ажилтан, үйлчилгээ, техник ажилтны цалин хөлсийг тогтоохдоо тухайн суугаа орны амьжиргааны өртөг, амьдралын нөхцөлийг харгалзах;

90.1.4.шүүгчийн цалингийн хэмжээ нь шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн өмнөх оныхоос жил бүр хоёр хувиар нэмэгдэж байх.

90.2.Төрийн албан хаагчийн дундаж цалингийн хэмжээ нь хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын цалингийн дунджаас 5.0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай саналыг Засгийн газар боловсруулж, төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэхийн өмнө Улсын Их Хуралд танилцуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

91 дүгээр зүйл. Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

91.1.Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөр олгоно:

91.1.1.албан томилолтын зардлыг;

91.1.2.албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн тохиолдолд батлагдсан нормативын дагуу гарсан зардлыг;

91.1.3.гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжинд нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшийн зардлыг;

91.1.4.төрийн албан хаагчийн бие махбодид албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадварыг түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

91.1.5.төрийн албан хаагчийн бие махбодид албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөгжлийн бэрхшээлтэй болж, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлын тодорхой хэсгийг нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх, зөрүүг улсын төсвөөс нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх.

91.2.Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчид олгох тусламж

92 дугаар зүйл. Төрийн албан хаагчид олгох тусламж

92.1.Төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 51.2.2, 51.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас нь тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн нийлбэрийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

92.2.Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт нь 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

Тайлбар: Төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэний амь насанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан хохирол учруулсан бол энэ хуулийн 92.2-т заасан буцалтгүй тусламжийг түүний ар гэрт мөн адил олгоно.

92.3.Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.

ХОРИН ДОЛООДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа

93 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа

93.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг баталгаагаар хангагдана:

93.1.1.албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;

93.1.2.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

93.1.3.гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх буцах төрийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;

93.1.4.албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага буюу цагдаагийн байгууллагаар хамгаалуулах;

93.1.5.орон байраар хангагдахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх;

93.1.6.Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

93.1.7.төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах;

93.1.8.үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх;

93.1.9.ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох.

93.2.Энэ хуулийн 93.1.5-д заасан баталгааг эдлүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар тогтооно.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл баталгаа

94 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл баталгаа

94.1.Төрийн захиргааны албан хаагч энэ хуулийн 92.1-д зааснаас гадна дараахь баталгаагаар хангагдана:

94.1.1.Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөхгүй, халагдахгүй байх;

94.1.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

94.1.3.төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан хаагч нь шалгаруулж авах;

94.1.4.төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгох.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч

95 дугаар зүйл. Дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч

95.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь албан хаагч цол, ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас хэрэглэнэ:

95.1.1.прокурор;

95.1.2.цагдаа;

95.1.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэгч;

95.1.4.тагнуулын болон түүний харьяа байгууллагын ажилтан;

95.1.5.онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын гал түймэр унтраах болон байгалийн гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагч;

95.1.6.хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа гааль, мэргэжлийн хяналт болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч.

95.2.Энэ хуулийн 95.1.1, 95.1.2-т заасан албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Ерөнхийлөгч, 95.1.3-95.1.6-д заасан албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Засгийн газар тус тус тогтооно.

VII ХЭСЭГ

ТӨРИЙН АЛБАНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

ГУЧДУГААР БҮЛЭГ

Засгийн газрын чиг үүрэг

96 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг

96.1.Засгийн газар нь төрийн албаны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, зохицуулалтын асуудлыг хариуцах бөгөөд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

96.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ хуулийн 96.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараахь асуудлыг хариуцна:

96.2.1.төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг хэрэгжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үүрэг, даалгавар өгөх, хэрэгжилтийг хангуулж, зөрчлийг арилгуулах, тэдэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

96.2.2.төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

96.2.3.төрийн албаны өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар төрийн албаны байгууллагуудыг хангах, төрийн албаны хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

96.2.4.төрийн албаны чадавхийг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас олгож буй зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах;

96.2.5.төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

96.2.6.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах;

96.2.7.Үндэсний статистикийн хороо болон эрх бүхий бусад байгууллагатай хамтран хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын дундаж цалингийн судалгааг гаргах;

96.2.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

96.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий сургалт, судалгааны байгууллага Төрийн удирдлагын академи ажиллана.

96.4.Энэ хуулийн 96.3-т заасан байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

97 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

97.1.Төрийн албаны зөвлөл нь улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг хөгжүүлэх, түүнийг хамгаалах зорилгоор зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах болон холбогдох бусад үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгөх, хэрэгжилтэд нь хяналт тавих, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, маргаан хянан шийдвэрлэх үндсэн үүрэг бүхий хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллага мөн.

97.2.Төрийн албаны зөвлөл үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

97.3.Төрийн албаны зөвлөл ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө.

97.4.Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно.

97.5.Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

97.6.Төрийн албаны зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоол, зөвлөмж гаргана. Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлнэ.

97.7.Төрийн албаны зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурал батална.

97.8.Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, нам, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

Тайлбар: Энэ хуулийн 97.8-д заасан хөндлөнгөөс нөлөөлөх гэдэгт хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхийг Төрийн албаны зөвлөл, түүний дарга, гишүүн, албан хаагчаас шаардах хамаарахгүй.

97.9.Энэ хуулийн 97.8-д заасныг зөрчсөн нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүнийг огцруулах, бусад албан тушаалтныг төрийн албанаас халах үндэслэл болно.

98 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэг

98.1.Төрийн албаны зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

98.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны удирдах албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

98.1.2.төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

98.1.3.төрийн албаны тухай хууль тогтоомж, чадахуйн зарчим /мерит/-ын хэрэгжилтийн талаар төрийн албаны байгууллагуудын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх;

98.1.4.төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн алба, албан хаагчтай холбогдолтой мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, бусад сонирхогч этгээдийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

98.1.5.хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх, биелэлтийг нь хангах;

98.1.6.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

98.1.7.төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

98.1.8.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах;

98.1.9.төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах;

98.1.10.төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас төрийн албанд олгож буй зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаархи мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардал, хийдэгдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

98.1.11.хууль тогтоомжид заасан бусад.

99 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн хуралдаан

99.1.Зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулах үндсэн хэлбэр хуралдаан байна.

99.2.Хуралдааны дэгийг Төрийн албаны зөвлөл тогтооно.

100 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн

100.1.Төрийн албаны зөвлөл орон тооны 3 гишүүнээс бүрдэнэ.

100.2.Төрийн албаны зөвлөлийн гишүүн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

100.2.1.тавин нас хүрсэн;

100.2.2.төрийн удирдлага, эдийн засаг, боловсрол судлал, хууль зүйн дээд боловсролтой /аль нэгийг хангасан байх/;

100.2.3.төрийн албаны удирдах албан тушаалд арваас доошгүй жил ажилласан байх;

100.2.4.хүний нөөцийн удирдлагын чиглэлээр мэдлэг, туршлага хуримтлуулсан байх.

100.3.Төрийн албаны зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас тус бүр нэг иргэнийг санал болгосноор Улсын Их Хурал хугацаагүйгээр томилно.

100.4.Зөвлөлийн гишүүнд улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан болон сүүлийн 1 жилийн хугацаанд эдгээр албан тушаалтнаар ажиллаж байсан хүнийг нэр дэвшүүлэхгүй.

100.5.Зөвлөлийн гишүүд нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн байж болохгүй.

Тайлбар: Энэ хуулийн 100.5-д “нэг нутгийн” гэснийг нэг аймаг, суманд төрснийг, “нэг анги хамт төгссөн” гэснийг ерөнхий боловсролын дунд сургууль, их, дээд, сургууль, коллежид нэг ангид хамт суралцаж төгссөнийг хамруулан ойлгоно.

100.6.Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч энэ хуулийн 100.2, 100.4, 100.5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

100.7.Байнгын хороо энэ хуулийн 100.6-д заасан үүргээ хүний эрхийг хамгаалах, ардчиллыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, их, дээд сургууль, коллежийн багш, профессор, Хуульчдын холбооны төлөөлөл бүхий 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгт шилжүүлж болно. Ажлын хэсгийн гишүүн сонирхлын зөрчилтэй байж болохгүй.

100.8.Энэ хуулийн 100.7-д заасан ажлын хэсгийн гишүүнд мөнгөн урамшуулал олгоно. Мөнгөн урамшууллын хэмжээ, олгох журмыг Байнгын хороо батална.

100.9.Байнгын хороо Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч энэ хуулийн 100.2, 100.4, 100.5-д заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд мөн хуулийн 100.3-т заасан эрх бүхий этгээд 5 хоногийн дотор өөр хүнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

101 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, түүний бүрэн эрх

101.1.Төрийн албаны зөвлөлийн даргаар зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн саналаа нууцаар хурааж, олонхийн санал авсан хүнийг 5 жилийн хугацаагаар сонгоно. Зөвлөлийн даргыг нэг удаа улируулан томилж болно.

101.2.Төрийн албаны зөвлөлийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

101.2.1.зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

101.2.2.зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд зөвлөлийн байр суурийг илэрхийлэх;

101.2.3.зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааны товыг зарлаж, даргалах;

101.2.4.хууль тогтоомжид заасан бусад.

101.3.Төрийн албаны зөвлөлийн дарга түр эзгүйд түүний үүргийг зөвлөлийн даргын томилсон гишүүн гүйцэтгэнэ.

101.4.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.

102 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх

102.1.Улсын Их Хурал дараахь үндэслэлээр Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж болно:

102.1.1.энэ хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

102.1.2.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

102.1.3.үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

102.1.4.өөр албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.

103 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг огцруулах

103.1.Улсын Их Хурал Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг дараахь үндэслэлээр огцруулна:

103.1.1.албан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчсөн;

103.1.2.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

103.1.3.энэ хуульд заасныг зөрчиж томилсныг эрх бүхий этгээд тогтоосон.

103.2.Төрийн албаны зөвлөлийн дарга зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргасан бол огцруулна.

103.3.Улсын Их Хурал энэ хуулийн 103.1.1, 103.1.3-т заасан тохиолдолд томилуулахаар нэр дэвшүүлсэн этгээдийн саналыг, 103.1.2-т заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг тус тус үндэслэн огцруулах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

104 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг нөхөн томилох

104.1.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол эрх бүхий этгээд өөр хүнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

104.2.Энэ хуулийн 104.1-д заасны дагуу томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний томилолтын үлдсэн хугацаатай адил байна.

105 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүний хууль зүйн баталгаа

105.1.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

105.2.Энэ хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

105.3.Хуульд зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

106 дугаар зүйл. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

106.1.Төрийн албаны зөвлөл үйл ажиллагааныхаа тайлан /цаашид “тайлан” гэх/-г жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Улсын Их Хуралд хүргүүлнэ. Тайланд дараахь асуудлыг тусгана:

106.1.1.төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын тухай болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүн;

106.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн талаарх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал;

106.1.3.төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний санал;

106.1.4.мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааны талаар цаашид авах арга хэмжээний санал.

106.2.Тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэн дүгнэлт гаргана.

106.3.Энэ хуулийн 106.2-т заасан дүгнэлтийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтлэх бөгөөд тайланг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор байрлуулна.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Маргаан хянан шийдвэрлэх

107 дугаар зүйл. Төрийн албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх

107.1.Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд гарсан төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдох маргааныг Төрийн албаны зөвлөл хянан шийдвэрлэнэ.

107.2.Төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигч гомдлоо баримтын хамт Төрийн албаны зөвлөлд 30 хоногийн дотор гаргана.

107.3.Төрийн албаны зөвлөл гомдлыг хүлээн авч хянаад 7 хоногийн дотор маргаан үүсгэх эсэх талаар шийдвэр гаргаж, 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 14 хоногоор сунгаж болно.

107.4.Маргаан үүсгэсэн тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн хянан шалгах эрх бүхий албан хаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

107.4.1.холбогдох этгээдээс тайлбар авах;

107.4.2.холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;

107.4.3.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

107.4.5.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

107.4.5.илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

107.4.6.хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

107.4.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

107.5.Энэ хуулийн 107.4-т заасан албан хаагч нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгээ болон эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, садан төрлийн хүмүүст холбогдох асуудлыг шалгахаас татгалзах, хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх үүрэгтэй.

108 дугаар зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

108.1.Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол энэ хуулийн 115.7-д зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны зөвлөл хүчингүй болгоно.

108.2.Энэ хуулийн 108.1-д заасан хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг Төрийн албаны зөвлөлийн мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох үүрэгтэй.

108.3.Төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигч Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

108.4.Энэ хуулийн 108.1, 108.2-т заасан шийдвэрийг гаргасан эрх бүхий этгээд нь Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг заавал биелүүлэх бөгөөд зөвлөлийн шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргахгүй.

108.5.Төрийн албаны зөвлөлийн болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 108.8-д зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны зөвлөл хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

108.6.Энэ хуулийн 108.5-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

108.7.Энэ хуулийн 108.6-д заасныг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд 5 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална.

108.8.Энэ хуулийн 108.5-д заасан хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг Төрийн албаны зөвлөлийн мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох үүрэгтэй.

108.9.Энэ хуулийн 108.1-д заасан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг Улсын Их Хурал тогтооно.

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

109 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

109.1.Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ..-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасгай:

1/төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээг эрдэмтэн, судлаач, шинжээчдийн оролцоотойгоор зохион байгуулж, дүнг 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн дотор Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулах;

2/хуульд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчдын цалингийн зэрэглэлийг тогтоохдоо ажлын байрны шинжилгээний дүнд тулгуурлан тухайн байгууллагын үйл ажиллагааны зохих хүрээ, албан тушаалын чиг үүрэг, хүлээх хариуцлагад тохирсон байхаар зохицуулах;

3/хуульд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо өмнө нь авч байсан цалин хөлсөөс дордуулахгүй байх арга хэмжээ авах;

4/Төрийн албаны тухай хуулийн 59.1, 62.1, 63.1, 64.1, 86.2, 87.1.1-д заасан төлөвлөгөө, 65.1, 66.1, 67.1, 77.1-д заасан тайлангийн загварыг боловсруулж, мөрдүүлэх, холбогдох байгууллага, албан хаагчдыг үе шаттайгаар сургалтад хамруулах.

2.Төрийн албаны зөвлөлийг өөрчлөн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн талаарх саналаа 2017 оны .. дугаар сарын ..-ны өдөрт багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Яамны Төрийн нарийн бичгийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Хуулиар яамыг татан буулгасан нь яамны Төрийн нарийн бичгийн даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Яамны Төрийн нарийн бичгийн даргыг улируулан томилж болно.

Тайлбар: Яамны Төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх Төрийн нарийн бичгийн даргын томилогдсон хугацааны үлдсэн хугацаатай адил байна.”

2/ 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, эрхлэх асуудлынх нь хүрээнд тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Хуулиар агентлагийг татан буулгасан нь агентлагийн даргыг үүрэгт ажлаас

чөлөөлөх үндэслэл болно. Агентлагийн даргыг улируулан томилж болно.

Тайлбар: Агентлагийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх даргын томилогдсон хугацааны үлдсэн хугацаатай адил байна.”

3/ 18³ дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлаг нэгээс илүүгүй дэд даргатай байна. Агентлагийн дэд даргыг хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.”.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохируулан Улсын Их Хурлаас тогтоосон” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Засгийн газрын агентлагийн даргаар зохих журмын дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд мөн хууль үйлчлэхгүй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газар энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны албан хаагчийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлөх бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасан нөхцөл, болзолыг хангасан иргэнийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, уг албан тушаалд шинээр томилно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Засгийн газрын агентлагийн даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.3 дахь хэсэг нэмсүгэй.

“10.3.Тухайн яамны чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 10.1-д заасан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулахыг хориглоно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “даргыг” гэсний дараа “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“9.1.Төрийн нарийн бичгийн даргыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар томилж, чөлөөлнө.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “стратегийг, ажлын байрны тодорхойлолтыг” гэснийг “стратегийг” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон

өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3 дахь хэсэг нэмсүгэй.

“9.3.Тухайн агентлагийн чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулахыг хориглоно.”

2 дугаар зүйл. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “стратеги, ажлын байрны тодорхойлолтыг” гэснийг “стратегийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн дугаарыг “9.4” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.8, 23.9 дэх хэсэг нэмсүгэй:

“23.8.Энэ хуулийн 23.7-д заасан тохиолдолд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд мөн хуулийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах талаар баталгаа гаргах бөгөөд түүнийг тухайн албан тушаалд томилох эсэхийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ.

23.9.Энэ хуулийн 23.8-д заасан баталгааны маягтыг Авлигатай тэмцэх газар батална.”

2 дугаар зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар 23.7 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“23.7.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол Авлигатай тэмцэх газар илт ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлын талаар энэ хуулийн 23.6-д заасан мэдэгдэлд тодорхой дурдана.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон

өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“10.2.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагын даргыг Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Төрийн албаны тухай хуулийн 35¹.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөж” гэснийг “Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архивын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“10.3.Үндэсний архивын газрын даргыг Засгийн газрын тухай 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.4 дэх хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“267.4.Гаалийн удирдах төв байгууллагын даргыг Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.5} дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“10.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Засгийн газрын тухай 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу тус тус санхүү, эдийн засаг, бүртгэлийн мэргэжилтэй иргэдээс сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“23.4.Аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Аймаг, нийслэлийн тээврийн албаны даргыг авто зам, тээврийн болон эдийн засгийн салбарын мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Аймаг, нийслэлийн авто замын газрын даргыг авто зам, тээврийн болон эдийн засгийн салбарын мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“20.3.Аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны даргыг газрын харилцааны зохих мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“5.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын даргыг инженер, техник, технологийн мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“3.Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“4.Улсын болон бүс нутгийн, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг тухайн салбарын мэргэжилтэй, соёл, урлагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулж томилно. Сонгон шалгаруулах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг доор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

“33.3.Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Засаг дарга 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Тамгын газрын даргыг улируулан томилж болно.

Тайлбар: Тамгын газрын даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх даргын томилолтын үлдсэн хугацаатай адил байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар зохих журмын дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд мөн хууль үйлчлэхгүй.

2 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны албан хаагчийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлөх бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасан нөхцөл, болзолыг хангасан иргэнийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, уг албан тушаалд шинээр томилно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны .. дугаар сарын ..-ны өдрийн хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ